



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/1/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Н.Отгонцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
Асуудлыг онцолсон хэсэг.....	2
Аудитын гол асуудал.....	2
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.4.2 Авлага .....	12
3.4.3 Бараа материал.....	13
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	13
3.4.5 Өр төлбөр.....	14
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 175  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Дархан сумын ИТХ-ын 2024 оны 03 дугаар тогтоолоор “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанаас хог тээврийг салган “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ыг байгуулж санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн орлогын төлөвлөгөөг 3,455.7 сая төгрөгөөр буюу 12.4 хувиар давуулан биелүүлж, аймгийн төсөвт 33,073.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

4525020313

## **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Дархан сумын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Дархан сумын ИТХ-аар хэлэлцээд, 94.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**


/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	10,539,658.4	6,607,242.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,343,682.0	2,909,865.2
33	АВЛАГА	1,130,850.8	1,238,909.2
34	УРЬДЧИЛГАА	0.0	88,415.3
35	БАРАА МАТЕРИАЛ	1,869,395.6	2,074,724.2
36	НӨӨЦИЙН БАРАА	14,360.0	40,500.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	70,002,258.7	83,216,937.2
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	70,002,258.7	83,216,937.2
39200	Биет хөрөнгө	40,694,121.5	52,010,077.6
39300	Биет бус хөрөнгө	29,308,137.2	31,206,859.6
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	80,541,917.1	89,824,179.5
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	407,735.1	234,832.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	407,735.1	234,832.1
41300	Өглөг	407,735.1	234,832.1
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	80,134,182.0	89,589,347.4
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	80,134,182.0	89,589,347.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	5,437,530.7	6,483,730.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	60,880,476.8	77,215,305.9
51200	Хуримтлагдсан үр дүн	12,308,555.6	4,382,691.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,507,619.0	1,507,619.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	80,541,917.1	89,824,179.5



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан


/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>43,113,755.4</b>	<b>63,623,160.2</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,490,288.6	48,330,187.6
110	Орлогын албан татвар	28,973,189.5	44,544,114.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,973,189.5	44,544,114.9
113	Хөрөнгийн албан татвар	2,006,155.4	1,949,274.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,510,943.7	1,836,798.2
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,364,514.4</b>	<b>4,859,466.1</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,364,514.4	4,859,466.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,258,952.4	10,433,506.5
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>40,009,502.2</b>	<b>67,044,369.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>40,009,502.2</b>	<b>67,044,369.8</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,199,841.4	27,268,565.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,666,135.1	11,822,130.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,163,046.8	1,375,218.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	811,217.6	2,880,121.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,254,522.6	1,301,925.7
2105	Нормативт зардал	369,940.9	473,236.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,189,706.9	2,534,185.1
2107	Томилот, зочны зардал	12,663.6	32,955.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	530,479.3	594,043.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,202,128.7	6,254,750.1
212	ТАТААС	151,424.9	250,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,658,235.9	39,525,804.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,104,253.2</b>	<b>(3,421,209.6)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,957,043.3</b>	<b>4,575,347.4</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,147,209.8</b>	<b>(7,996,556.9)</b>



### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,762,879.1	1,507,619.0	11,167,872.0	69,438,370.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,526.2)	(6,526.2)
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>56,762,879.1</b>	<b>1,507,619.0</b>	<b>11,161,345.8</b>	<b>69,431,843.8</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	9,555,128.3	-	-	9,555,128.3
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,318,007.4	1,507,619.0	12,308,555.6	80,134,182.0
11	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	66,318,007.4	1,507,619.0	12,308,555.6	80,134,182.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,693.2	70,693.2
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>66,318,007.4</b>	<b>1,507,619.0</b>	<b>12,379,248.8</b>	<b>80,204,875.2</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,797,752.5	-	-	11,797,752.5
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	5,583,276.7	-	-	5,583,276.7
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,996,556.9)	(7,996,556.9)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,699,036.6	1,507,619.0	4,382,691.9	89,589,347.4



## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	42,356,336.10	62,242,453.20
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	32,490,288.60	48,330,187.60
110	Орлогын албан татвар	28,973,189.50	44,544,114.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,973,189.50	44,544,114.90
113	Хөрөнгийн албан татвар	2,006,155.40	1,949,274.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,510,943.70	1,836,798.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	241,438.10	508,906.30
1181	Газрын төлбөр	1,177,889.50	1,327,891.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	91,616.10	-
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	2,797,785.40	3,838,900.10
120	Нийтлэг татварын бус орлого	2,797,785.40	3,838,900.10
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	7,068,262.20	10,073,365.50
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	35,133,692.60	61,656,200.40
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	35,133,692.60	61,656,200.40
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	16,353,475.20	21,839,228.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,405,007.10	11,796,940.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	1,410,828.00	1,406,060.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	747,486.10	3,075,781.20
2104	Хангамж, бараа материалын зардал	1,055,236.10	1,156,658.10
2105	Нормативт зардал	351,953.00	377,800.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,021,882.00	2,488,407.80
2107	Томилолт, зочны зардал	12,663.60	32,955.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	573,239.60	488,045.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,775,179.70	1,016,578.60
212	ТАТААС	151,424.90	250,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,628,792.50	39,566,971.90
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	7,222,643.50	586,252.80
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	2,250,573.60	5,020,069.60
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	2,250,573.60	5,020,069.60
2200	Дотоод эх үүсвэрээр	2,250,573.60	5,020,069.60
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	(2,250,573.60)	(5,020,069.60)
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	(395,300.00)	-
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	395,300.00	-
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	4,576,769.90	(4,433,816.80)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,766,912.10	7,343,682.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,343,682.00	2,909,865.20



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	23,396,624.6	21,597,111.0	(1,799,513.6)	92.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	18,284,960.1	17,215,867.4	(1,069,092.7)	94.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17,406,976.1	16,366,379.3	(1,040,596.8)	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,026,060.1	3,866,373.6	(159,686.5)	96.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	512,882.6	424,341.2	(88,541.4)	82.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,801,147.0	2,052,117.4	(749,029.6)	73.3
2104	Хангамж, бараа материалын зардал	90,783.7	87,991.4	(2,792.3)	96.9
2105	Нормативт зардал	3,900.0	3,711.8	(188.2)	95.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,721,037.3	1,720,439.6	(597.7)	100.0
2107	Томилолт, зочны зардал	13,800.0	11,445.3	(2,354.7)	82.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,427,323.4	7,421,391.4	(5,932.0)	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	810,042.0	778,567.6	(31,474.4)	96.1
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>250,000.0</b>	<b>250,000.0</b>	-	<b>100.0</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>627,984.0</b>	<b>599,488.1</b>	<b>(28,495.9)</b>	<b>95.5</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	308,620.0	298,620.0	(10,000.0)	96.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	319,364.0	300,868.1	(18,495.9)	94.2
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,611,664.5</b>	<b>4,381,243.6</b>	<b>(230,420.9)</b>	<b>95.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>500,000.0</b>	-	<b>(500,000.0)</b>	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23,396,624.6</b>	<b>21,870,270.1</b>	<b>(1,526,354.5)</b>	<b>93.5</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,611,664.5	4,406,881.5	(204,783.0)	95.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,196,992.8	17,136,549.5	(1,060,443.3)	94.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	587,967.3	326,839.0	(261,128.3)	55.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	239,025.9	239,025.9	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	512,185.0	512,185.0	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,998.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,998.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,998.9</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	1,068.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	180.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,750.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>34,998.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,998.9</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,998.9



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан сумын ТЕЗ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг явуулах чиг үүргийн хүрээнд “Иргэд, олон нийтийн санал санаачилгад тулгуурлан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого шийдвэрийг боловсруулж хэрэгжүүлнэ” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сумын ТЕЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн төсвийн шууд захирагч бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,282.1 сая төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,343.7	2,909.9	(4,433.8)
Авлага	1,130.8	1,238.9	108.1

/сая төгрөгөөр/

Урьдчилгаа	0.0	88.4	88.4
Бараа материал	1,869.4	2,074.7	205.3
Нөөцийн бараа	14.4	40.5	26.1
Бусад эргэлтийн хөрөнгө	181.4	254.8	73.4
Үндсэн хөрөнгө	70,002.3	83,216.9	13,214.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>80,542.0</b>	<b>89,824.1</b>	<b>9,282.1</b>
Өр төлбөр	407.8	234.8	(173.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	80,134.2	89,589.3	9,455.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>80,542.0</b>	<b>89,824.1</b>	<b>9,282.1</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө 4,433.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны эцэст “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн зээлийн төлбөр 5,640.5 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Харин авлагын данс 108.1 сая төгрөгөөр өссөн нь 5 өрхийн эмнэлэгт эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн 394.3 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа данс өсөхөд Дархан сумын ЗДТГ-ын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр 86.8 сая төгрөгийг шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын 205.3 сая төгрөгийн өсөлтөд төсвийн хөрөнгөөр 3,345.3 сая төгрөгийн материал худалдан авсан, 623.4 сая төгрөгийн материал хандиваар авсан, 3,763.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд бусад хангамжийн материал, барилгын засварын материал 34.6 хувийг, аж ахуйн материал 36.6 хувийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн данс 13,214.8 сая төгрөгөөр өссөн нь ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-т 16,298.2 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг орлогод бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр данс буурахад “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 177.1 сая төгрөгийн өр төлбөр барагдсан нь нөлөөлжээ

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,455.2 сая төгрөгөөр өссөн нь “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 10,292.1 сая төгрөгийн, “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ийн 5,620.0 сая төгрөгийн хөрөнгийн өсөлт болон тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,909.8 сая төгрөг болж, өмнөх оноос 4,433.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	-
Банканд байгаа бэлэн мөнгө	7,343.7	2,909.8	(4,433.9)
Төгрөг	7,343.7	2,909.8	(4,433.9)
Төрийн сангийн харилцах	6,959.2	1,393.5	(5,565.7)
Арилжааны банк дахь харилцах	384.4	1,516.3	1,131.9
<b>Дүн</b>	<b>7,343.7</b>	<b>2,909.8</b>	<b>(4,433.9)</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 2,909.8 сая төгрөгийн 1,393.5 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 1,516.3 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцахад байгаа 1,393.5 сая төгрөгийн 878.3 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 73.9 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 438.3 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, 3.0 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа дансны үлдэгдэл бөгөөд арилжааны банкин дахь 1,516.3 сая төгрөгийн 164.3 сая төгрөг нь 5 өрхийн эмнэлгийн, 1,352.0 сая төгрөг нь 3 ОНӨААТҮГ-ын дансны үлдэгдэл байна.

**Аудитын илрүүлэлт:**

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 455.1 сая төгрөгийн дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Дархан сумын ЗДТГ албан хаагчид шинжилгээнд хамрагдаагүй байхад 86.7 сая төгрөгийн гэрээний төлбөрийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн, мөнгөн гүйлгээний тайланд 355.7 сая төгрөгийн тайлант оны төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй,
- Дархан сумын ИТХ санхүүгийн ажилтнуудад 2.0 сая төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон,
- “Амин холбоо” ӨЭМТ нягтлан бодогчид 0.3 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон,
- Дархан сумын ХХС нь сангийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн скайнер худалдан авсан,
- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь албан хаагчид 0.6 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 7.5 сая төгрөгийн зардал гаргасан,
- “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь тушаал шийдвэргүйгээр 0.3 сая нэмэгдэл хөлс олгосон,
- “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ нь албан хаагчид 0.4 сая төгрөгийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх алдаа, зөрчлүүдээс аудитын явцад 442.3 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 3.3 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 2.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,238.9 сая төгрөг болж, өмнөх оноос 108.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	1.2	1.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	190.7	394.3	203.6
Татаас санхүүжилтийн авлага	0.0	156.6	156.6
Дансны авлага /ТӨҮГ/	2.8	1.2	(1.6)
Байгууллагаас авах авлага	16.5	16.5	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	920.6	669.1	(251.5)
<b>Дүн</b>	<b>1,130.8</b>	<b>1,238.9</b>	<b>108.1</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст авлага данс 108.1 сая төгрөгөөр өссөн нь 5 өрхийн эмнэлэгт эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн 394.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн татаас санхүүжилтийн авлага 156.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 251.5 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

Нийт авлагын 54.0 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн, 31.8 хувийг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн, 12.6 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн, 1.6 хувийг төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна*

**3.4.3 Бараа материал**

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 1,869.4 сая төгрөг байснаас оны эцэст 2,074.7 сая төгрөг болж, 205.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>380.2</b>	<b>324.5</b>	<b>(55.7)</b>
Тусгай зориулалттай материал	99.9	108.6	8.7
Эм боох материал	280.3	215.9	(64.4)
<b>Хангамжийн материал</b>	<b>1,489.2</b>	<b>1,750.2</b>	<b>261.0</b>
Бичиг хэргийн материал	19.8	20.1	0.3
Аж ахуйн материал	671.9	760.9	89.0
Сэлбэг хэрэгсэл	153.2	203.7	50.5
Түлш, шатах тослох материал	24.3	46.5	22.2
Барилгын засварын материал	238.0	383.2	145.2
Бусад хангамжийн материал	382.0	335.8	(46.2)
<b>Дүн</b>	<b>1,869.4</b>	<b>2,074.7</b>	<b>205.3</b>

*Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдлийн 51.8 хувь нь ОНӨААТҮГ-т, 17.8 хувь нь төсөвт байгууллагад, 30.4 хувь нь 5 өрхийн эмнэлэгт бүртгэлтэй байна.

Бараа материалын 205.3 сая төгрөгийн өсөлтөд төсвийн хөрөнгөөр 3,345.3 сая төгрөгийн материал худалдан авсан, 623.4 сая төгрөгийн материал хандиваар авсан, 3,763.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд бусад хангамжийн материал, барилгын засварын материал 34.6 хувийг, аж ахуйн материал 36.6 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Бараа материал данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна*

**3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 83,216.9 сая төгрөг болж, өмнөх оноос 13,214.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>40,694.0</b>	<b>52,010.0</b>	<b>11,316.0</b>
Барилга, байгууламж, орон сууц	13,784.1	12,985.4	(798.7)
Авто-тээврийн хэрэгсэл	3,057.2	4,126.7	1,069.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,334.2	2,434.3	100.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	426.8	575.2	148.4
Зам гүүрийн байгууламж	4,324.1	4,070.5	(253.6)
Бусад үндсэн хөрөнгө	16,767.6	27,817.9	11,050.3

<b>Биет бус хөрөнгө</b>	<b>29,308.1</b>	<b>31,206.8</b>	<b>1,898.7</b>
Программ хангамж	18.1	13.1	(5.0)
Бусад биет бус хөрөнгө	29,290.0	31,193.7	1,903.7
<b>Дүн</b>	<b>70,002.1</b>	<b>83,216.9</b>	<b>13,214.8</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 15.8 хувь нь төсөвт байгууллагуудад, 81.1 хувь нь ОНӨААТҮГ-т, 3.1 хувь нь 5 өрхийн эмнэлэгт бүртгэлтэй байна. Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 62.5 хувийг биет хөрөнгө, 37.5 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансанд ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-т 16,298.2 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг орлогод бүртгэсэнтэй холбоотойгоор өссөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Дархан сумын ЗДТГ 6.3 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу бүртгэсэн, 1,046.2 сая төгрөг бүхий газрыг орлогод авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн, аймгийн ОНХС, ОНХО-аар бий болсон 20.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- “Госхот” ӨЭМТ нь 12.3 сая төгрөгийн контейнерийг барилга байгууламжид бүртгэсэн,
- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь 143.3 сая төгрөгийн шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 2.7 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцоолсон,
- “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь 38,943.7 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй бүртгэсэн,
- “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ нь 5,714.5 сая төгрөгийн эздийн өмчийн дүнг зөрүүтэй тусгасан

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх 45,889.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

**3.4.5 Өр төлбөр**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 407.7 сая төгрөг байснаас оны эцэст 234.7 сая төгрөг болж 173.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	14.6	0.0	(14.6)
Байгууллагад төлөх өглөг	215.9	233.5	1.3
Татварын өглөг /ТӨҮГ/	0.0	1.2	1.2
Дансны өглөг /ТӨҮГ/	177.2	0.0	177.2
<b>Дүн</b>	<b>407.7</b>	<b>234.7</b>	<b>173.0</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 97.0 хувь буюу 230.4 сая төгрөг нь ОНХС-ийн чанарын баталгаа байна. “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 177.1 сая төгрөгийн гудамжны нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн цахилгааны төлбөр, Шунхлай ХХК-д шатахууны өр төлбөрийг барагдуулсан нь буурахад нөлөөлжээ.

**Аудитын илрүүлэлт:**

- “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ 2.5 сая төгрөгийн, Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ нь нь 2.6 сая төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх 5.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 89,589.3 сая төгрөг болж, өмнөх оноос 9,455.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	5,437.5	6,483.7	1,046.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	60,880.5	77,215.3	16,334.8
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>12,308.5</b>	<b>4,382.7</b>	<b>(7,925.8)</b>
Өмнөх үеийн үр дүн	11,161.3	12,379.2	1,217.9
Тайлант үеийн үр дүн	1,147.2	(7,996.5)	(6,849.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,507.6	1,507.6	0.0
<b>Дүн</b>	<b>80,134.1</b>	<b>89,589.3</b>	<b>9,455.2</b>

Эх сурвалж: Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,455.2 сая төгрөгөөр өссөн нь “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 10,292.1 сая төгрөгийн, “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ийн 5,620.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнгээр нэмэгдсэн, 7,996.5 сая төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр буурсан зэргээс шалтгаалжээ.

**Аудитын илрүүлэлт:**

Засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2024 оны төсвийн төсөлд ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 3,767.6 сая төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг 37,711.0 сая төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдлийг 515.0 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 3,972.9 сая төгрөгөөр тус тус тооцож, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 45,966.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 20,428.5 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 25,538.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг сумын ИТХ хэвээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвийг тайлант хугацаанд төсвийн зохицуулалт, тодотголыг тус бүр 1 удаа хийсэн бөгөөд тодотголоор урьд оны үлдэгдэл 3,404.4 сая төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг 6,933.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга

хэмжээг 165.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, урсгал зардалд 2,968.1 сая төгрөг, аймгийн төсөвт төвлөрүүлэх зардлыг 7,535.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Гүйцэтгэлээр ОНХС-аас 4,406.9 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвийн орлогоор 17,136.5 сая, үйл ажиллагааны орлогоор 326.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,597.1 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлснээр 749.0 сая төгрөгийг хэмнэлт үүссэн, ХХС-ийн 500.0 сая төгрөгийн зээл олгогдоогүй, ОНХС-ийн 230.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ дараагийн онд шилжсэн зэргээс тус тус шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дархан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Статистикийн хэлтсээс мал тооллоготой холбоотой зардалд 0.6 сая төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн санхүүжилт 14.4 сая төгрөг, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 20.0 сая төгрөг, нийт 35.0 сая төгрөгийн орлого төвлөрч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сумын ИТХ-ын суудалтай намуудад олгосон дэмжлэгтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Отгонцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан сумын Засаг дарга 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/279 тоот албан бичгээр 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 23,396.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 350.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан сумын ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төсвийг төлөвлөхдөө зардлын ангилал журам, зааврын дагуу төлөвлөхтэй холбоотой 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	151.4	1	151.4	100
Нийт дүн	1	151.4	1	151.4	100

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,896.9 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- “Э-тайлан” цахим системд цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 298.6 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул “э-тайлан” цахим системд нэмж залруулав.

- Санхүүгийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд 5,640.5 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн төвлөрүүлэх шилжүүлэг дансанд нэмж тусган залруулав.

Аудитаар сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 298.6 сая төгрөгийн дэмжлэг олгосон зөрчил<sup>2</sup> илэрсэн тул цаашид хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс дэмжлэг олгосонтой холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Тус сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 298.6 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”; 34 дүгээр зүйлийн 34.6-д “нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”, 34.6.3-т “төрийн байгууллага болон нутгийн өөрөөр удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3 дахь заалтыг баримталж, аудитын тайлан хүргүүлсэн өдрөөс хойш орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,896.9 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- “Э-тайлан” цахим системд цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 298.6 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул “э-тайлан” цахим системд нэмж залруулав.

- Санхүүгийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд 5,640.5 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тусгаагүй нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн төвлөрүүлэх шилжүүлэг дансанд нэмж тусган залруулав.

Аудитаар сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 298.6 сая төгрөгийн дэмжлэг олгосон зөрчил<sup>2</sup> илэрсэн тул цаашид хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс дэмжлэг олгосонтой холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Тус сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 298.6 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”; 34 дүгээр зүйлийн 34.6-д “нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”, 34.6.3-т “төрийн байгууллага болон нутгийн өөрөөр удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3 дахь заалтыг баримталж, аудитын тайлан хүргүүлсэн өдрөөс хойш орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>3</sup> Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ТЕЗ	2	5,896.9			2	5,896.9	2	5,896.9				
ЗДТГ	6	1,515.0			6	1,515.0	6	1,515.0				
“Гос хот” ӨЭМТ	1	12.3			1	12.3	1	12.3				
“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ	3	147.3			3	147.3	3	147.3				
“Дархан хотын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ	1	38,943.7			1	38,943.7	1	38,943.7				
“Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ	1	5,714.5			1	5,714.5	1	5,714.5				
<b>Дүн</b>	<b>14</b>	<b>52,229.7</b>			<b>14</b>	<b>52,229.7</b>	<b>14</b>	<b>52,229.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	1,422.1					1	1,422.1				
ИТХ	1	2.0			1	2.0						
“Амин холбоо” ӨЭМТ	1	0.3	1	0.3								
ХХС	2	1.6	1	1.6			1	-				
“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ	5	10.6	1	0.6	1	-	3	10.0				
“Дархан хотын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ	2	10.2	1	0.3			1	9.9				
“Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ	2	3.0	1	0.4			1	2.6				
ТЕЗ	1	298.6					1	298.6				
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>1,748.4</b>	<b>5</b>	<b>3.2</b>	<b>2</b>	<b>2.0</b>	<b>8</b>	<b>1,743.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/						
			Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ИТХ	1	-						1	-
“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ	1	-			1	-			
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
МЭДС ТОВ	1	-						1	-
Гэрэлтэй ӨЭМТ	1	-						1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>		<b>2</b>	<b>-</b>

**Долоо. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	9	8	1		9			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ОНӨҮГ	3	3			3			
5	ТЕЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>13</b>	<b>12</b>	<b>1</b>		<b>13</b>			